



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 334

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 4,892,000.00 (дөрвөн сая найман зуун ерэн хоёр мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржав, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Л.Баттөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

А.АРИУНБОЛД

Ц.ТҮВШИНЗАЯА

0000625

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
2019 оны 07 дугаар сарын 22-ны өдр  
334 дугаар тогтоолын хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН САНХҮҮ, АЖ АХУЙН АЛБАНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛЭГТ БАЛАНСААС БАЛАНСАД  
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Үндсэн хөрөнгийн нэр           | Ашиглалтад орсон он | Нэг бүрийн үнэ (төгрөг) | Тоо шир хэг | Балансын нийт үнэ (төгрөг)                                              | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл (төгрөг)                                              |
|-----|--------------------------------|---------------------|-------------------------|-------------|-------------------------------------------------------------------------|--------------------------------|----------------------------------------------------------------|
| 1   | Хөргөгч (мини, сорьц хадгалах) | 2018                | 2,000,000.00            | 1           | 2,000,000.00                                                            | -                              | 2,000,000.00                                                   |
| 2   | Хүчилтөрөгчийн аппарат         | 2018                | 1,320,000.00            | 2           | 2,640,000.00                                                            | -                              | 2,640,000.00                                                   |
| 3   | Кварцын гэрэл                  | 2018                | 252,000.00              | 1           | 252,000.00                                                              | -                              | 252,000.00                                                     |
|     | Нийт дүн                       |                     |                         |             | 4,892,000.00<br>(дөрвөн сая<br>найман зуун ерэн<br>хоёр мянга<br>мөнгө) | -                              | 4,892,000.00<br>(дөрвөн<br>найман зуун<br>хоёр мянга<br>мөнгө) |